



УХААЛАГ ЗАСАГ – 2 ТӨСӨЛ SMART GOVERNMENT II PROJECT

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

“Ухаалаг засаг - 2” төслийн “Төслийн хөгжлийн зорилго” (ТөХЗ) нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлэх төрийн цахим үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, дижитал ур чадвар, дижитал технологи бүхий ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино.

САНХҮҮЖИЛТ: Дэлхийн банк

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам

ХУГАЦАА: 2023-2027 он

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ I. Дижитал шилжилтийн таатай орчныг бүрдүүлэх;

ДИЖИТАЛ ШИЛЖИЛТИЙН ТАЛААРХ БОДЛОГО, ДҮРЭМ, ЖУРМЫГ САЙЖРУУЛАХ;

- Дижитал шилжилттэй холбоотой хууль, эрх зүйн зохицуулалт, бодлого, институтын тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүн шинжилгээ хийж, техникийн тусалцаа үзүүлэх.

ТӨСЛИЙН ДИЖИТАЛ ЗАСГИЙН ЧИГЛЭЛЭЭРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТАД ЗОРИУЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ;

- Төрийн дижитал шилжилтийг нэвтрүүлэх, ашиглахад тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлох, холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэх, төрийн албан хаагчид болон оролцогч талуудын өөрчлөлтийг манлайлах, мэдээлэх талаар чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

ИРГЭДИЙН ЦАХИМ ОРОЛЦООГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ;

- Олон нийт, нийгмийн бүлгүүдтэй харилцах онлайн платформ, хэрэгслийг нэвтрүүлэх, ашиглах.

БҮРЭЛДЭХҮҮН ХЭСЭГ I. ГОЛЛОХ АЖЛУУД, ҮР ДҮН

Дижитал хөгжлийг дэмжих бодлого, зохицуулалтын баримт бичгүүдийг боловсруулахад дэмжлэг үзүүлж зөвлөх ажлын хүрээнд дижитал шилжилтийг дэмжих хоёр хууль, гурван журам боловсруулахад хамтран ажиллалаа. *Батлагдсан хууль, журмууд:*

ХУУЛЬ:

- [1] Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;
- [2] Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/.

ЖУРАМ:

- [1] Эрүүл мэндийн болон ЦХХХ-ны сайдын 2024.03.26-ны А/138, А/37 тоот хамтарсан тушаалаар баталсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний програм хангамжид тавигдах шаардлага болон эдгээр программ хангамжид үнэлгээ хийх, шаардлагад нийцсэн программ хангамжийг мэдээлэх журам;
- [2] Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор баталсан Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах хадгалах, аюулгүй байдлыг хангах журам;
- [3] Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор баталсан Бүх нийтийн тоон бичиг үсгийн бүтцийн хүрээ



“ЦАХИМ БАРИМТ БИЧГИЙН ХУУЛЬ ЁСНЫ ХҮЧИНТЭЙ БАЙДАЛ БА СОРИЛТ, ШИЙДЭЛ” ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Цахим баримт бичгийг цаасан баримт бичигтэй адил түвшинд ашиглах санал зөвлөмж боловсруулах зорилгоор дараах ажлыг зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэлээ.

- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 31, Эрүүл мэндийн яамны 19, Архивын ерөнхий газрын 23 нийт 73 эрх зүйн актын баримтад дүн шинжилгээ хийж, хийдэл, зөрчил, давхардлыг тодорхойлон, санал асуулга, фокус группын ярилцлагыг зохион байгуулж, санал зөвлөмжийг боловсруулав.
- Эстони, Солонгос, Сингапур, Япон, Европын холбоо, Америк зэрэг зургаан орны цахим баримт бичгийн болон цахим гарын үсгийн эрх зүйн орчныг шинжилж, харьцуулсан судалгааг хийлээ.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйл ажиллагааг цахимжуулах хүрээнд 49 тусгай зөвшөөрөл олгох процессд дүн шинжилгээ хийж, одоо хэрэгжиж буй 186, шинэ процессын 212 зураглалыг боловсруулав. Түүнчлэн 15 тусгай зөвшөөрөл олгох процессыг холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцэж байгаа эсэх судалгааг хийж санал зөвлөмжийг гаргалаа.

ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЖ, ҮР АШИГТАЙ БАЙДЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ, СТРАТЕГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ;

- Үндэсний дата төв болон түүний Нөөц дата төвийг шинэчлэх;
- Үндэсний дата төв, түүний Нөөц дата төвийн техник хангамжийн хүчин чадлыг сайжруулж үндэсний үүлэн тооцооллын платформ болгон хувиргах;
- Холбогдох төрийн байгууллагуудын дундын хэрэглээнд зориулсан нийтлэг үйлчилгээ идэвхжүүлэгчийг нэмэх;
- Арилжааны үүлэн тооцооллын үйлчилгээ ашиглах боломжийг үнэлэх, төвлөрсөн бус дэд бүтэц бүхий захын тооцооллын загварыг нэвтрүүлэх;
- Үндэсний дата төв, түүний Нөөц дата төвийн хөргөлтийн болон эрчим хүчний системийн эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх.

“ҮНДЭСНИЙ ДАТА ТӨВ” УТУГ БОЛОН “НӨӨЦ ДАТА” ТӨВИЙГ ШИНЭЧЛЭХ ХҮРЭЭНД:

Төрийн байгууллагуудын цахим шуудангийн аюулгүй, хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэв. “Төрийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуульд зааснаар төрийн байгууллага, албан тушаалтан нь албан и-мэйл болон холбогдох дэмжих системийг ашиглах үүрэгтэй тул уг системийг үргэлжүүлэн ашиглах эрхийг төслийн хүрээнд сунгав. Энэ хүрээнд өнөөдрийн байдлаар 710 байгууллагын 970 домейнд 61,706 хэрэглэгч өдөрт дунджаар 30,000 имэйл хүлээн авч, 100,000 имэйл илгээгдэж байна.

“Үндэсний дата төв” УТУГ болон “Нөөц дата” төвийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, хүчин чадлыг өргөтгөж байна. Төслийн хүрээнд “Үндэсний дата төв”-ийн (ҮДТ) хүчин чадлыг 30 хувиар нэмэгдүүлсэнээр 2027 он хүртэлх нөөц хэрэгцээг хангах боломжийг бүрдүүлэхийн сацуу үйлчилгээ үзүүлж буй мэдээллийн системүүдийн найдвартай, бүрэн ажиллах, онцгой нөхцөлд нийт нөөцийн 50 хувийг “Нөөц төв”-д хадгалж хэвийн ажиллагааг хангах чадамжийг бий болгох юм. Мөн одоогийн нөөц цахилгаан хангамжийг дизель генератороор шинэчилэн, эрчим хүчний хүчин чадлыг 60 хувиар нэмэгдүүлнэ. Энэхүү шинэчлэл нь өндөр ба нам хүчдэлийн цахилгаан хангамж, хөргөлтийн систем болон бусад дэд тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг ханган, тоног төхөөрөмжийн хяналт, ашиглалтыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Монгол Улсын интернет харилцах холболтын техник хангамжийг Layer 3-аас Layer 2 болгон шинэчлэв. Ингэснээр интернетийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон нийт хэрэглэгчид үндэсний хэмжээнд хурдны хязгаарлалтгүйгээр дотоодын цахим хуудас, цахим систем, өгөгдөл солилцох, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх төхөөрөмжийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж байна.

Үүлэн тооцооллын үйлчилгээг ашиглах үнэлгээ, судалгаа хийгдэж байна. Төрийн мэдээллийн сангийн дэд бүтэц, хадгалах багтаамж, гамшгаас хамгаалах механизмыг сайжруулах үүднээс үүлэн систем рүү шилжих шаардлага манай улсад бий. Ингэснээр мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагааны уялдаа холбоог дэмжих чухал ач холбогдолтой юм. Төслийн хүрээнд үүлэн технологи руу амжилттай шилжихэд шаардагдах үр ашиг, эрсдэл, хэрэгжүүлэх стратеги зэргийг тооцох нарийн үнэлгээ, судалгааны ажлыг хэрэгжүүлж байна.



Ахмад настай иргэдийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээг амжилттай зохион байгуулав. Төслийн хүрээнд ахмад настай иргэдийн цахим ур чадварыг сайжруулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын 9 дүүрэг болон 13 аймгийн давхардсан тоогоор 1,208 орчим ахмадын төлөөллийг хамруулсан сургалт, арга хэмжээг биечлэн болон цахим хэлбэрээр зохион байгуулсан юм. Энэхүү хөтөлбөрт сайн дурын 137 оюутан, залуус идэвхтэй оролцож цахим ур чадвар нэмэгдүүлэх сургалт, арга хэмжээнд сургагч багшаар ажиллалаа. Сургалтын дараах мэдлэг бататгах үнэлгээгээр хөтөлбөрт хамрагдсан нийт ахмадын цахим ур чадвар, мэдлэг мэдээлэл дунджаар 49 хувиар нэмэгдсэн байна.

**АХМАД НАСТАЙ ИРГЭДИЙН ЦАХИМ
УР ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ГАРЫН
АВЛАГЫГ ЭНДЭЭС ТАТАЖ ҮЗНЭ ҮҮ.**



ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭХ МЕХАНИЗМ

Төслийн нэгж нь төслийн гүйцэтгэл, ялангуяа байгаль орчин ба нийгмийн нөлөөлөл, цаашлаад төслийн үйл ажиллагаатай холбоотой нөлөөлөлд өртсөн хүмүүсийн санал, гомдлыг хүлээн авах, бүртгэх эдгээрт хариу өгөх, зохих арга хэмжээ авахад дэмжлэг үзүүлэх механизмыг хэрэгжүүлэн ажилладаг. Энэ хүрээнд дараах байдлаар өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна.

ХЭН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ГАРГАХ ЭРХТЭЙ ВЭ?

Төсөл болон төслийн хүрээнд хэрэгжүүлж үйл ажиллагаа нь тэдний байгаль орчин, нийгэмд, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлсэн, эсвэл үзүүлэх боломжтой гэж үзэж буй хувь хүн, байгууллага, төсөлд оролцогч, төслөөс үр шим хүртэгчид өргөдөл, гомдол, санал, хүсэлт гаргах эрхтэй.

Төсөл болон төслийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой хуулиар зөвшөөрөгдсөн мэдээлэл авах зорилгоор хувь хүн, байгууллага, төсөлд оролцогч, сонирхогч, үр шим хүртэгчид өргөдөл, гомдол, санал, хүсэлт гаргах эрхтэй.

1 → 2 → 3 → 4 → ӨРГӨДӨЛ, САНАЛ ГОМДОЛ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ҮЕ ШАТУУД:

НЭГ. ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ШИЙДВЭРЛЭХ БОЛОН ӨГШМ-Д ХАНДАХ

- ӨГШМ-ын тогтолцоо нь нөлөөлөлд өртөгч иргэдэд (орон нутгийн оршин суугчид, орон нутгийн аж ахуйн нэгжийн төлөөлөл, гэрээт ажил гүйцэтгэгчдийн ажилчид гэх мэт) тухайн үед мөрдөгдөж буй Монгол Улсын Засгийн газрын журмын хүрээнд тусгай зориулалтын шууд утсаар, биечлэн, цахим шуудан, сошиал сувгаар дамжуулан өргөдөл гаргах зэрэг хэд хэдэн хувилбараас хамгийн тохиромжтойг нь сонгон гомдол, санал хүсэлт гаргах боломж олгодог.

ХОЁР. ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШАЛГУУРЫГ ҮНЭЛЭХ, ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- Хүлээж авсан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх асуудлыг ТХН-ийн холбогдох ажилтан хариуцдаг. ТХН асуудлыг шалгаж шийдвэрлэх алхам хийж байх хэрэгтэй. Энэ нь гэрээт ажил гүйцэтгэгчид засч залруулах арга хэмжээ авах зааварчилгааг агуулсан байж болно. Гэрээт ажил гүйцэтгэгч нь өргөдөл, гомдлыг шийдвэрлэх шийдлийг хэрэгжүүлж, үр дүнг ТХН-д уламжилж, энэ талаар Дэлхийн банкинд мэдэгдэх ёстой. ТХН/Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь гомдол гаргасан асуудлын төрөл, нарийн төвөгтэй байдлаас хамааран өргөдөл, гомдлыг хүлээн авснаас хойш 1-30 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

ГУРАВ. ТӨСЛИЙН УДИРДАХ ХОРООНЫ ТҮВШИНД ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- “УХААЛАГ ЗАСАГ-2 төслийн Удирдах Хороо нь шаардлагатай тохиолдолд 3 дахь үе шат эхэлсэнээс хойш 10 хоногт багтаан олон талт оролцогч талуудын уулзалт хийх боломжийг судалж зохион байгуулах арга хэмжээ авна.

ДӨРӨВ. ДЭЭД ТҮВШНИЙ ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГЫН ШУГАМААР АСУУДЛЫГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- Гаргасан өргөдөл, гомдлыг нь хянан шийдвэрлээгүй тохиолдолд, нөлөөлөлд өртсөн талууд шүүхэд хандан хохирлоо шийдвэрлэх боломжтой.



ТА ДАРААХ ХАЯГААР САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДЛОО ГАРГАХ БОЛОМЖТОЙ.

+976-51-261068

www.smart.gov.mn

info@smart.gov.mn

smartgov2mongolia

smartgovll

Ухаалаг Засаг-2 Төсөл